

Аудитын код: САГ-2018/6/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gungidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Жавхлан
Утас : 261628 Цахим хаяг: javhlang@audit.gov.mn
Аудитор Ц.Цэрэнхүү
Утас: 261628 Цахим хаяг: tserenkhuuts@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	1
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт.....	2
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	3
2.9.1	Зардлын талаар:.....	3
2.9.2	Бараа материал, үндсэн хөрөнгийн хөрөнгийн талаар:.....	3
2.9.3	Хандив, тусламжийн хөрөнгийн талаар:.....	3
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	5
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	5
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	5
2.16	Аудитаар тооцсон үр өгөөжийн талаар	5
3	Менежментийн захидал.....	6
3.1	Зардлын талаар	7
3.2	Хандив, тусламжийн хөрөнгийн талаар	8
3.3	Үндсэн хөрөнгийн талаар.....	9
3.4	Авлага, өглөгийн талаар.....	10
3.5	Мөнгөн хөрөнгийн талаар	11
3.6	Төсвийн санхүүжилтийн талаар	12
3.7	Дотоод хяналтын талаар.....	13
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	Error! Bookmark not defined.
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	Error! Bookmark not defined.
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	Error! Bookmark not defined.
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	Error! Bookmark not defined.
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	Error! Bookmark not defined.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Т.БАДРАЛ
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.



Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ОЮУНБИЛЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 03 дугаар сарын 5-наас 2018 оны 03 дугаар сарын 19-ний хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан, аудитор Ц.Цэрэнхүү нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2018 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 9/445 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Онцгой байдлын ерөнхий газар санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн аудитын байгууллага тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Онцгой байдлын ерөнхий газар нь Монгол Улсын хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхийг нэмэгдүүлэх замаар Монгол хүний аюулгүй амьдрах таатай нөхцлийг бүрдүүлж, улс орны нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлого, үндэсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй байгууллага юм.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Тус салбарын гол зорилт нь Онцгой байдлын алба эрхэлсэн байгууллагын албан хаагчдын сахилга бат, ёс зүй, хариуцлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хүч хэрэгслийн бэлэн байдал, чадавхийг бэхжүүлэх асуудал юм.

Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан. /ТАБ-СТА-А-1/

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 4 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 11 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.


Онцгой байдлын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан, түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Онцгой байдлын ерөнхий газар нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Онцгой байдлын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хөвийн гэж үзлээ.



2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар урсгал зардалд 78,848.2 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн захирагч нь 2017 онд урсгал зардалд 74,371.9 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 4,476.3 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Онцгой байдлын ерөнхий газрын шилэн дансанд сар, улирал, хагас, бүтэн жилээр оруулах мэдээллээ хуулийн хугацаанд нь тус тус оруулж төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган, сар болгоны төсвийн гүйцэтгэл, 5 сая төгрөгөөс дээш гүйлгээ, 2017 оны батлагдсан төсөв, төсвийн тодотгол, хуваарь, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, сар бүрийн төсвийн гүйцэтгэл зэргийг мэдээллэж хэвшсэний гадна Дотоод хяналт, шалгалт аюулгүй байдлын газраас төв орон нутгийн онцгой байдлын анги, хэлтэс, газар, салбар 41 нэгжийн шилэн дансны хөтлөлт, хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт нь арилгуулан тайланг улирал бүр Шадар сайдын ажлын албанд хүргүүлэн ажилласан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан /ТАБ-СТА-В-3/ маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно. Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Зардлын талаар:

Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар батлагдсан төсвийг нийт дүнгээр хэтрүүлээгүй боловч зардлын зүйл тус бүрээр хянагдах зарим зардлын төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна. Тухайлбал: бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 39.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах талаар аудитын албан шаардлага өгөх;


2.9.2 Бараа материал, үндсэн хөрөнгийн хөрөнгийн талаар:

Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь бараа материал, үндсэн хөрөнгийн дүнг жилийн эцсийн бараа материал, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлтэй тулган шалгахад байвал зохих үлдэгдлийг тайлант оны эхний үлдэгдлээр авч нэгтгэн тооцоо бодсоноос бараа материал 663.6 сая, үндсэн хөрөнгө 611.8 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн “үнэн зөв байдал” буюу “Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв бүртгэсэн байх..” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Уг асуудлыг аудитын явцад залруулсан болно.

2.9.3 Хандив, тусламжийн хөрөнгийн талаар:

ОБЕГ-ын харьяа Давтан сургалт, сэргээн заслын төвд ашиглагдаж байгаа НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төслөөс нийлүүлэгдсэн 17.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг данс



бүртгэлд тусгаагүй, 79.9 сая төгрөгийн тавилга эд хогшлыг ашиглагч байгууллагад нь шилжүүлж өгөөгүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн “Санхүүгийн тайлангийн дуусвар болсон өдөр хөрөнгө, авлага уг аж ахуйн нэгж байгууллагад хамааралтай эзэмших, бүртгэх эрхтэй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх

2.9.4 Үндсэн хөрөнгийн талаар:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр төсвийн урсгал зардлаас 34.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8-д “Төрийн өмчийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх

2.9.5 Авлагын талаар:

Салбарын хэмжээнд улсын нөөцийн барааны авлага өмнөх оноос 537.7 сая төгрөгөөр өссөн, өглөг 271.7 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх

2.9.6 Мөнгөн хөрөнгийн талаар:

Харилцах дансны баримтыг түүвэрлэн шалгаж үзэхэд анхан шатны үндсэн баримтын бүрдэлгүйгээр нийт 48.6 сая төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх

2.9.7 Төсвийн санхүүжилтийн талаар:

МУЗГ-ын 2016 оны 66 дугаар тогтоолоор байгуулагдсан ОБЕГ-ын харьяа “Давтан сургалт, сэргээн заслын төв “ УТҮГ-ын төсвийн санхүүжилт дутагдснаас цалин, халаалтын зардлыг ОБЕГ-аас санхүүжүүлж ирсэн байна. Тайлант онд дээр дурдсан зардалд нийт 184.3 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 42 дугаар зүйлийн 42.3.1-д “Төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалах..төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх



2.9.8 Дотоод хяналтын талаар:

ОБЕГ-ын харьяа байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,269.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 61.8 сая төгрөгийн 18 төлбөрийн акт, 375.5 сая төгрөгийн 13 албан шаардлага, 1,832.4 сая төгрөгийн 33 зөвлөмж өгч, Нийслэл, Орхон, Өвөрхангай, Ховд аймгийн Онцгой байдлын газрууд, Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс зэрэг 5 байгууллага “Хязгаарлалттай” санал дүгнэлт, Завхан аймгийн Онцгой байдлын газар “Сөрөг” санал дүгнэлт авсан байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулж, хязгаарлалттай болон сөрөг санал дүгнэлт авсан байгууллагуудын холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох талаар аудитын албан шаардлага өгөх

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар нарийвчлан шалгах эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,219.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба аудитын явцад эд хөрөнгийн тооллого, тооцоотой холбоотой 1,275.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, бусад зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Онцгой байдлын ерөнхий газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 3 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн биелүүлж ажилласан байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Материаллаг байдлын түвшинг 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 105,468.9 сая төгрөгийн 2 хувиар буюу 2,109.4 сая төгрөгөөр тогтоов.


2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

2.16 АУДИТААР ТООЦСОН ҮР ӨГӨӨЖИЙН ТАЛААР

Аудитаар ОБЕГ-ын аппаратын эд хөрөнгийн тооллого, тооцсон зарцуулсантай холбоотой нийт 1,275.4 сая төгрөгийн үр өгөөж гарсан болно.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Онцгой байдлын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 ЗАРДЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Онцгой байдлын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар батлагдсан төсвийг нийт дүнгээр хэтрүүлээгүй боловч зардлын зүйл тус бүрээр хянагдах зарим зардлын төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.Тухайлбал: бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 39.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Төсөв хэтрэх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, хууль тогтоомж зөрчигдөх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.2 ХАНДИВ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

ОБЕГ-ын харьяа Давтан сургалт, сэргээн заслын төвд ашиглагдаж байгаа НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төслөөс нийлүүлэгдсэн 17.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгаагүй, 79.9 сая төгрөгийн тавилга эд хогшлыг ашиглагч байгууллагад нь шилжүүлж өгөөгүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн “Санхүүгийн тайлангийн дуусвар болсон өдөр хөрөнгө, авлага уг аж ахуйн нэгж байгууллагад хамааралтай эзэмших, бүртгэх эрхтэй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах, зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн холбогдох заалт зөрчигдөх, хөрөнгө үрэгдэх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.3 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр төсвийн урсгал зардлаас 34.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.8-д “Төрийн өмчийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах, зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Холбогдох хуулийн заалт зөрчигдөх, төсвийг зориулалт бусаар зарцуулах.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.4 Авлага, өглөгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №4

ҮАГ-ын ажиглалт

Салбарын хэмжээнд улсын нөөцийн барааны авлага өмнөх оноос 537.7 сая төгрөгөөр өссөн, өглөг 271.7 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай” хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах, зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Холбогдох хуулийн заалт зөрчигдөх, төсвийг зориулалт бусаар зарцуулах.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.5 МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №5

ҮАГ-ын ажиглалт

Харилцах дансны баримтыг түүвэрлэн шалгаж үзэхэд анхан шатны үндсэн баримтын бүрдэлгүйгээр нийт 48.6 сая төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан , мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2018 оны оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Холбогдох хуулийн заалт зөрчигдөх, төсвийг үр ашиггүй зарцуулах,

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.6 ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №6

ҮАГ-ын ажиглалт

МУЗГ-ын 2016 оны 66 дугаар тогтоолоор байгуулагдсан ОБЕГ-ын харьяа “Давтан сургалт, сэргээн заслын төв “ УТҮГ-ын төсвийн санхүүжилт дутагдсанаас цалин, халаалтын зардлыг ОБЕГ-аас санхүүжүүлж ирсэн байна. Тайлант онд дээр дурдсан зардалд нийт 184.3 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай ”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", 42 дугаар зүйлийн 42.3.1-д “Төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалах..төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна .

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай” хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах, зөвлөмжийн биелэлтийг 2018 оны оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөх, төсвийг үр ашиггүй зарцуулах,

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.7 Дотоод хяналтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №7

ҮАГ-ын ажиглалт

ОБЕГ-ын харьяа байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,269.7 сая төгрөгийн зөрчил илэрч, Нийслэл, Орхон, Өвөрхангай, Ховд аймгийн Онцгой байдлын газрууд, Багануур дүүргийн Онцгой байдлын хэлтэс зэрэг 5 байгууллага “Хязгаарлалттай” санал дүгнэлт, Завхан аймгийн Онцгой байдлын газар “Сөрөг” санал дүгнэлт авсан байна.

ҮАГ-ын зөвлөмж

Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулж ажиллах, биелэлтийг 2018 оны оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөх, төсвийг үр ашиггүй зарцуулах,

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Ү з ү л э л т	Э х н и й ү л д э г д э л	Э ц с и й н ү л д э г д э л
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	95,138,965.7	102,729,861.8
31	Мө Н Г ө Н Х ө Р ө Н Г ө	74,419.3	116,803.1
31100	К а с с а н д б а й г а а б э л э н м ө н г ө	3,317.0	5,440.3
31110	Т ө г р ө г	3,317.0	5,440.3
31200	Б а н к и н д б а й г а а б э л э н м ө н г ө	71,102.3	111,362.8
31210	Т ө г р ө г	71,102.3	111,362.8
31211	Т ө р и й н с а н г и й н х а р и л ц а х	5,050.0	25,966.8
31213	А р и л ж а а н ы б а н к д а х ь х а р и л ц а х	9,222.2	39,499.6
31215	Н э м э л т с а н х ү ү ж и л т и й н х а р и л ц а х	56,830.1	45,896.4
33	А В Л А Г А	2,965,379.1	5,619,889.1
33100	А ж и л л а г ч и д т а й х о л б о г д с о н а в л а г а	15,802.9	5,968.6
33300	Т а т а а с , с а н х ү ү ж и л т и й н а в л а г а	0.0	2,104,969.7
33500	Б у с а д а в л а г а	2,949,576.2	3,508,950.8
33510	Б а й г у у л л а г а а с а в а х а в л а г а	2,780,601.7	3,467,254.7
33520	Х у в ь х ү м ү ү с э э с а в а х а в л а г а	168,974.5	41,696.1
34	У Р Ъ Д Ч И Л Г А А	151,344.4	176,451.8
